



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/15

Санхмэндатай

Худгийн цахилгаан хангамжийн
гэрээ байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Худгийн цахилгаан хангамжийг иргэн Д.Отгонбилэгтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Дээрх ажилтай холбогдон гарах зардал 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.
3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Засаг даргын орлогч (О.Базаррагчаа), Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

4823020029